



**БУЛГАН АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



Хүн амын амьдарч
буй орчин, нийгмийн үзүүлэлт
2022

**ХҮН АМЫН АМЬДАРЧ
БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ
2022**



2023 он



БУЛГАН АЙМАГ



Байгуулагдсан он	1938
Аймгийн төв	Булган
Сумын тоо	16
Багийн тоо	75
Газар нутгийн талбай	48,733.0км ²
Хүн ам	62026
Хүн амын нягтрал	1.3
Угсаатан	Халх
Утасны код	+976 (0)134
Шуудангийн дугаар	63000
Тээврийн хэрэгслийн улсын дугаар	БУА, БУЛ
ISO 3166-2	MN-067
Аймгийн цахим хуудас	www.bulgan.nso.mn

ГАРЧИГ

- I. АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- II. ХҮН АМ, ӨРХИЙН ТАИЛЦУУЛГА
- III. АХУЙН НӨХЦӨЛ, ОРЧИН
- IV. СУРАЛЦАХ ОРЧИН
- V. ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН
- VI. АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БУЛГАН АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

Булган аймаг нь манай орны төв хэсэгт Орхон Сэлэнгийн сав газарт оршдог. Аймгийн нутаг дэвсгэр нь XX дугаар зуунаас өмнөх үед дараах овог аймаг, улс гүрэнд харьяалагдаж байлаа. Үүнд:

- МЭӨ болон МЭ–ний эхэн үед Хүннү улсын нутаг дэвсгэр
- МЭ–ний II–V зуунд Жүжаан, Сяньби, Тоба улсын нутаг дэвсгэр
- VI–VIII зуунд Түрэг
- VIII–IX зуунд Уйгур
- IX–X зуунд Киргиз
- X–XII зуунд Хидан/Ляо/
- XII–XIII зуунд Мэргэд, Хэрэйд, найман, Урианхай зэрэг овог аймаг
- XIII–XV зуунд Монголын эзэнт улсын нутаг дэвсгэрт хамаарагдаж байлаа.
- XVI зууны дунд үеэс Халхын 4 аймгийн нэг Түшээт хан аймагт харьяалагдах болсон.

Аймгийн нутаг дэвсгэр нь Манжийн ноёрхлын үе болон Богд хаант Монгол улсын үед Түшээт хан аймагт, Ардын засгийн эхний жилүүдэд Богд хан уулын аймагт харьяалагдаж байлаа.



I.БУЛГАН АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

Булган аймаг нь Түшээт хан аймаг, Түшээт ханы хошуунд хамрагдаж байгаад, 1691 оноос Дайчин вангийн хошуу болжээ. Мөн 1924 оноос өмнөх үед Булган, Бугат, Хангал, Сайхан, Орхон, Сэлэнгэ сумд нь дайчин вангийн хошуу, Бүрэгхангай сум Жонон гүний, Дашинчилэн, Баяннуур сум Үйзэн гүний, Гурванбулаг сум нь Түшээт хааны, Хишиг-Өндөр, Могод сум нь Баруун гүний, Баян-Агт сум Үржин гүний, Хутаг-Өндөр сумын баруун тал нь Жанжий гүний, зүүн тал нь Дайчин вангийн 1918 онд Баатар вангийн, Тэшиг сумын баруун хэсэг нь Ар гөрөөчний отогт харьяалагдаж байгаад 1924 онд Орхоноос хойших сумд үндсэндээ Булган хан уулын хошуу болсон байна.

Анх аймаг байгуулагдахдаа 15 сум 128 баг, 10360 өрх, 43500 хүн амтай, нийт хүн амын 49.5 хувь нь эрэгтэй, 50.5 хувь нь эмэгтэйчүүд, 1.1 сая толгой малтай, 42250 ам км нутагтай байгуулж, Сэлэнгэ аймгаас Сайхан, Хантай, Сэлэнгэ, Булган, Сэлэнгэбүрэн, Халиун, Хангал, Цонхлон сумд, Төв аймгаас Бүрэгхангай, Авзага сум, Хөвсгөл аймгаас Тэшиг, Хутаг-Өндөр, Намнан, Баян-Агт сум, Архангай аймгаас Могод сумыг Булган аймагт харъяалуулж байсан байна.

Аймгийн төв Булган сум нь далайн төвшингөөс дээш 1210 м өндөрт, Улаанбаатар хотоос 318 км, агаараар 265 км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос 335 км, Төв аймгийн төв Зуунмод хотоос 379 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос 348 км, Архангай аймгийн төв Цэцэрлэг хотоос 282 км, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос 364 км дөрвөн замын уулзварт байдаг.

Хангайн нурууны салбар бэсрэг уулс Хантай, Булган хан, Хан жаргалант, Дулаан хан, Намнан, Хутаг-Өндөр, Онгон сарьдаг, Сардиг бүтээл, Бөхөн шарын нуруу, Бүрэн хан, Могодын нуруу, Авзага хайрхан, Бүрэгхангай, Хөгнө хан, Лах баян, Өрхтэй, Баянзүрх, Баян-Агт зэрэг 2000 метрээс дээш өндөр 20 гаруй уул нуруудтай. Хамгийн өндөр цэг нь Хантай нурууны оргил Давлин 2171 м, хамгийн нам дор газар нь Сэлэнгэ мөрний сав, Сүмийн булан, Ингэт толгой орчим далайн түвшингээс дээш 950 м байдаг.

Сэлэнгэ, Орхон, Туул, Эг, Хануй, Харбух, Тарвагтайн тарни, Хангал, Ингэт, Хужир, Баянгол, Зэлтэр, Алтайд, Ачуут, Могой, Төлбөр, Балиг, Цагаан гол зэрэг 388 гол горхи, 369 булаг шандтай. Хунт, Хульж, Хануй, Цагаан гол, Чин толгой, Чулуут, Хөөвөр, Зүүнтүрүү зэрэг 30 орчим рашаантай.

Уур амьсгал нь эх газрын эрс тэс сэрүүвтэр чийглэг 1-р сарын дундаж температур нь Булган хотын орчимд -22.80 , 7-р сард 16.50 , үнэмлэхүй дулаан нь 34.8 хэм, үнэмлэхүй хүйтэн нь -44.10 , жилийн дундаж тунадас 324 мл боловч, зарим жил 500 мл-с дээш байдаг. Салхины дундаж хурд 2.2 м/с, цасан бүрхүүлийн дундаж зузаан Булган орчимд 15-25 см, түрүүчийн цас 9-р сарын дундуур, сүүлийн цас 5-р сарын дундуур ордог. Хур бороо элбэгтэй учир агаар чийглэг, харьцах чийглэгийн жилийн дундаж 63 хувь байдаг.

Жилийн турш цэлмэг өдөр зонхилж 68-108, бүрхэг өдөр 12-66 байдаг. Байгалийн баялагт ашигт малтмалаас алт, мөнгө, зэс, молибден, хар тугалга, чулуун нүүрс, оюу, номин, болор, гантиг, боржин чулуу, барилгын төрөл бүрийн материал, элс хайрга, хүрмэн бай шохойн чулуу, зос, будаг элбэг.

Тус аймаг нь 2022 оны жилийн эцэст 61 717 хүн амтай. Нийт хүн амын 50.9 хувь нь эрэгтэй, 49.1 хувь нь эмэгтэйчүүд, 18336 буюу 29.7 хувь нь 0-14 насны хүүхэд, 16 997 буюу 27.5 хувь нь 15-34 насны залуучууд, 24 368 буюу 39.5 хувь нь 35-69 насныхан, 2 016 буюу 3.3 хувь нь 70-аас дээш ахмадууд тус тус эзэлж байна. Хүн амын 12 817 буюу 20.8 хувь нь аймгийн төв Булган суманд амьдарч байна.

Аймгийн хэмжээнд 19098 өрх байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 29 өрх буюу 0.2 хувиар өссөн байна. Байршилаар нь авч үзвэл нийт өрхийн 3840 буюу 20.1 хувь нь аймгийн төвд, 929 буюу 4.9 хувь нь тосгонд, 4 612 буюу 24.1 хувь нь сумын төвд, 9 717 буюу 50.9 хувь нь хөдөөд амьдарч байна.

Аймгийн нийт сум төвийн эрчим хүчинд холбогдсон. Холбоо мэдээллийн шинэ дэвшилтэт технологи бүрэн нэвтэрсэн. Үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн болон хувийн хэвшлийн 1186 гаруй нэгжтэй, томоохон хот сууринтай хатуу хучилттай замаар холбогдсон. Хангайн гурил ХХК, Хонгор агро ХХК, Зана дура зорбак ХХК зэрэг томоохон үйлдвэрүүдтэй.

Урьдчилсан гүйцэтгэлээр 2022 онд Булган аймаг нь 543.3 тэрбум төгрөгийн ДНБ-н бий болгосны 65.6 хувийг хөдөө аж ахуйн салбар, 13.1 хувийг үйлдвэрлэл, 21.3 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна. Урьдчилсан гүйцэтгэлээр Булган аймаг нь хангайн бүсийн ДНБ-ний 7.7 хувь буюу 543.3 тэрбум төгрөгийг бүрдүүлж өмнөх оноос 57.6 сая төгрөг буюу 11.8 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 8.7 сая төгрөг болсон байна. Хангайн бүсийн аймгуудын ДНБ-ний 48.5 хувийг Орхон аймаг бүрдүүлсэн байна.

ХОТ, АЙМАГ, СУМ ХООРОНДЫН ЗАМЫН УРТ, км

Улаанбаатар																				
Эрдэнэт	371																			
Булган	318	68																		
Баян-Агт	468	218	150																	
Баяннуур	196	248	181	330																
Бугат	370	32	52	202	232															
Бүрэгхангай	259	128	80	230	100	132														
Гурванбулаг	276	208	140	290	80	172	80													
Дашинчилэн	226	218	150	300	30	182	70	150												
Могод	338	199	131	281	120	163	108	75	90											
Орхон	296	90	22	152	158	54	58	118	128	109										
Рашаант	210	288	220	370	110	252	140	70	70	140	198									
Сайхан	419	269	101	72	281	153	181	241	251	232	123	321								
Сэлэнгэ	439	67	135	285	315	101	215	275	285	266	157	355	236							
Тэшиг	564	314	246	183	426	298	326	386	396	377	268	466	243	381						
Хангал	326	60	113	263	293	92	193	253	263	244	135	333	214	80	359					
Хишиг-Өндөр	275	136	68	218	105	100	45	92	75	63	46	142	169	203	314	181				
Хутаг-Өндөр	461	211	143	80	323	195	223	283	293	274	165	363	177	278	103	256		211		
	Улаанбаатар	Эрдэнэт	Булган	Баян-Агт	Баяннуур	Бугат	Бүрэгхангай	Гурванбулаг	Дашинчилэн	Могод	Орхон	Рашаант	Сайхан	Сэлэнгэ	Тэшиг	Хангал		Хишиг-Өндөр	Хутаг-Өндөр	

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Сумын нэр	Байгуулагдсан он	Багийн тоо
Булган аймаг	1937	75
Баян-Агт	1931	6
Бугат	1924	3
Бүрэгхангай	1930	4
Гурванбулаг	1930	6
Дашинчилэн	1930	4
Могод	1931	5
Орхон	1924	5
Сайхан	1924	6
Сэлэнгэ	1959	5
Тэшиг	1930	5
Хангал	1924	4
Хишиг-Өндөр	1931	5
Хутаг-Өндөр	1924	5
Булган	1938	6
Баяннуур	1959	2
Рашаант	1985	4

АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ ТОМООХОН, УУЛ НУРУУД


Орших сум нэр	Уул нурууны нэр	Өндөр
Хутаг-Өндөр	Хантай	2171
Бугат	Ханжаргалант	2069
Тэшиг	Дулаан хан	2058
Могод	Дулаан хар	2058

ТОМООХОН НУУРУУД

Орших сум нэр	Нуурын нэр	Талбай хэмжээ кв.км
Баян-Агт	Шарга	6
Тэшиг	Харгал	8
Баян-Агт	Цэгээн	5
Тэшиг	Олон нуур	2
Хутаг-Өндөр	Айрхан	3
Сайхан	Хунт	0.8
Сайхан	Өрмийн цагаан нуур	0.7
Баяннуур	Баяннуур	1.9

ТОМООХОН ГОЛ МӨРӨН

Гол мөрний нэр	Нийт урт км	Аймгийн нутаг дэвгэрээр урсах км
Сэлэнгэ мөрөн	992	228
Эгийн гол	475	198
Орхон гол	1124	328
Хануйн гол	421	84




Суурин хүн амын тоо
61717


Өрхийн тоо
19098

II. ХҮН АМ, ӨРХ

Хүйсийн харьцаа




НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



18 хүртэлх
21783



Гэрт
10413



Түр оршин суугаа
34



Хаягандаа амьдардаггүй
2,844



55-аас дээш
9948



Байшинд
7658



Түр эзгүй
193



Гадаадад оршин суугч
682

Хүүхдийн ачаалал*



45.8



Хөгшидийн ачаалал*



8.2




Хүн ам зүйн ачаалал*



54.0

* - Энэхүү үзүүлэлт нь 15–64 насны нийт хүн амд ногдох 0–14 насны хүүхэд, 65 ба түүнээс дээш насны хүн амын харьцааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны хүн ам болоод хөдөлмөрийн бус насны хүн ам хоорондын харьцаа юм.

Зураг 1. Хүн амын тоо оноор, мян.хүн



Хүснэгт 1. Хүн амын тоо, сумаар, хүйсээр

Сум	Хүн ам		2022	Эрэгтэй		2022	Эмэгтэй		2022
	2021	2022		2021	2022		2021	2022	
	тоо		хувь	тоо		хувь	тоо		хувь
Нийт	61 938	61 717	99.6	31487	31 413	99.8	30 451	30 304	99.5
Баян-Агт	3364	3 375	100.3	1691	1 697	100.4	1673	1678	100.3
Баяннуур	1858	1 878	101.1	989	999	101.0	869	879	101.2
Бугат	2202	2 144	97.4	1161	1 139	98.1	1041	1005	96.5
Булган	12810	12 817	100.1	6263	6 287	100.4	6547	6530	99.7
Бүрэгхангай	2927	2 924	99.9	1514	1 513	99.9	1413	1411	99.9
Гурван булаг	3286	3 267	99.4	1684	1 680	99.8	1602	1587	99.1
Дашинчилэн	3049	3 008	98.7	1540	1 525	99.0	1509	1483	98.3
Могод	2681	2 666	99.4	1379	1 376	99.8	1302	1290	99.1
Орхон	3385	3 364	99.4	1806	1 796	99.4	1579	1568	99.3
Рашаант	3202	3 204	100.1	1612	1 617	100.3	1590	1587	99.8
Сайхан	3578	3 559	99.5	1823	1 810	99.3	1755	1749	99.7
Сэлэнгэ	3330	3 355	100.8	1768	1 770	100.1	1562	1585	101.5
Тэшиг	3621	3 568	98.5	1851	1 829	98.8	1770	1739	98.2
Хангал	4543	4 528	99.7	2271	2 271	100.0	2272	2257	99.3
Хишиг-Өндөр	3056	3 021	98.9	1557	1 541	99.0	1499	1480	98.7
Хутаг-Өндөр	5046	5 039	99.9	2578	2 563	99.4	2468	2476	100.3

Хүснэгт 2. Хүн амын тоо, сумаар, хүйсээр, хот хөдөөгөөр

Сум	Аймаг			Сумын төв			Тосгон			Хөдөө		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Нийт	12 817	6 287	6 530	14 337	7 087	7 250	2 956	1 470	1 486	31 607	16 569	15 038
Баян-Агт				610	287	323				2 765	1 410	1 355
Баяннуур				619	317	302				1 259	682	577
Бугат				827	415	412				1 317	724	593
Булган	12 817	6 287	6 530	-	-	-				-	-	-
Бүрэгхангай				940	444	496				1 984	1 069	915
Гурван булаг				540	264	276				2 727	1 416	1 311
Дашинчилэн				888	442	446				2 120	1 083	1 037
Могод				440	209	231				2 226	1 167	1 059
Орхон				873	444	429				2 491	1 352	1 139
Рашаант				1 592	781	811				1 612	836	776
Сайхан				730	355	375				2 829	1 455	1 374
Сэлэнгэ				1 817	934	883				1 538	836	702
Тэшиг				1 022	496	526				2 546	1 333	1 213
Хангал				427	197	230	2 956	1 470	1 486	1 145	604	541
Хишиг-Өндөр				996	489	507				2 025	1 052	973
Хутаг-Өндөр				2 016	1 013	1 003				3 023	1 550	1 473

Суурин хүн амын 19 385 буюу 31.4 хувь нь 0-15 насныхан, 35 481 буюу 58.1 хувь нь 16-59 насныхан, 6491 буюу 10.5 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байна. 90-ээс дээш насны 75 өндөр настан байгаагаас 95 настай 4, 96 настай 3, 97 настай 2, 98 настай 2, 100 настай 1 хүн байгаа нь Рашаант сумын өндөр настан байна.



II.2. ГЭР БҮЛ

Хүснэгт 3. Гэр бүл

2022 онд 206 гэрлэлт бүртгэгдэж, 44 гэрлэлт цуцлагдаж, 23 хүүхэд үрчлэгдсэн байна. Өмнөх оноос гэрлэлт 25.4 хувиар, үрчлэлт 20.7 хувиар буурч, гэр бүл цуцлалт 10.0 хувиар өссөн байна. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 23.8 хувь нь 20-24 насныхан, 40.7 хувь нь 25-29 насныхан, 17.5 хувь нь 30-34 насныхан, эмэгтэйчүүдийн 34.5 хувь нь 20-24 насныхан, 29.6 хувь нь 25-29 насныхан, 15.5 хувь нь 30-34 насныхан байна.

Үзүүлэлт	2021 он	2022 он	2022 2021
	тоо		хувь
Гэрлэлт	276	206	25.4
Цуцлалт	40	44	10.0
Үрчлэлт	29	23	20.7

II.3. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон эцэг, эх 1946, үүнээс эмэгтэйчүүд 1514, өмнөх оноос 6.2 хувиар, эрэгтэйчүүд 432, өмнөх оноос 14.6 хувиар тус тус буурсан байна. Улсын нийт өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 2.3 хувь нь Булган аймагт байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоогоороо улсад 19-т орж байна.

Хүснэгт 4. Өрх толгойлсон эх, эцэг

Үзүүлэлт	Байршил					Ам бүлийн тоо		
	Бүгд	Аймгийн төв	Сумын төв		Хөдөө	3 хүртэлх	3-5	6, түүнээс дээш
			Тосгон					
	тоо							
Бүгд	1946	116	67	1175	588	1020	660	266
Эх	1514	70	55	958	431	743	549	222
Эцэг	432	46	12	217	157	277	111	44

Аймгийн хэмжээнд 36 бүтэн өнчин хүүхэд, 801 хагас өнчин хүүхэд байна. Өмнөх оноос хагас өнчин хүүхдийн тоо 10.0 хувиар, бүтэн өнчин хүүхдийн тоо 2.8 хувиар өссөн байна.

Бүтэн өнчин хүүхдийн тоо



2021

35

2022

36

↑
2.8%

Хагас өнчин хүүхдийн тоо



2021

728

2022

801

↑
10.0%

Өрх толгойлсон эх



2021

1614

2022

1514

↓
6.2%

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүн



2021


1328

2022

1361

↑
10.0%

Зураг 2. Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, хүйсээр



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ


Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо өмнөх оноос 80 хүнээр буюу 3.4 хувиар, эмэгтэй 60 буюу 6.5 хувиар тус тус өссөн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 14.8 хувийг харааны, 3.2 хувийг ярианы, 8.9 хувийг сонсголын, 21.3 хувийг хөдөлгөөний, 19.9 хувийг сэтгэцийн, 7.4 хувийг хавсарсан, 24.4 хувийг

бусад төрлийн бэрхшээлтэй иргэн эзэлж байна.


Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүн

Үзүүлэлт	Бүгд			Байршил			
	Тоо	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Аймгийн төв	Тосгон	Сумын төв	Хөдөө
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	2437	980	160	57	102	1260	1018
Харааны	361	133	23	4	10	183	164
Ярианы	78	36	6	5	3	41	29
Сонсголын	217	93	17	5	7	106	99
Хөдөлгөөний	519	186	36	17	20	296	186
Сэтгэц	487	225	6	16	27	251	193
Хавсарсан	180	63	19	-	2	58	120
Бусад	595	244	53	10	33	325	227

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бэрхшээлийн төрлөөр



Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүйсээр, төрлөөр





II.5. ӨРХ

Аймгийн хэмжээнд 19 098 өрх байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 29 өрх буюу 0.2 хувиар өссөн байна. Байршилаар нь авч үзвэл нийт өрхийн 3840 буюу 20.1 хувь нь аймгийн төвд, 929 буюу 4.9 хувь нь тосгонд, 4 612 буюу 24.1 хувь нь сумын төвд, 9 717 буюу 50.9 хувь нь хөдөөд амьдарч байна.



Хүснэгт 6. Өрх, сумаар, хот, хөдөөгөөр

Сум	Бүгд		Аймгийн төвд		Хот, тосгонд		Сумын төвд		Хөдөөд	
	2 021	2 022	2 021	2 022	2 021	2 022	2 021	2 022	2 021	2 022
	Тоо									
Нийт өрх	19 069	19 098	3 819	3 840	925	929	4 647	4 612	9 678	9 717
Баян-Агт	961	969					210	195	751	774
Баяннуур	509	523					168	187	341	336
Бугат	791	785					278	283	513	502
Булган	3 819	3 840	3 819	3 840						
Бүрэгхангай	895	895					305	303	590	592
Гурван булаг	967	948					198	187	769	761
Дашинчилэн	908	922					300	302	608	620
Могод	853	845					161	154	692	691
Орхон	1 184	1 172					310	305	874	867
Рашаант	999	1 000					499	493	500	507
Сайхан	1 099	1 107					231	231	868	876
Сэлэнгэ	1 084	1 092					588	594	496	498
Тэшиг	1 006	1 013					307	290	699	723
Хангал	1 493	1 502			925	929	134	135	434	438
Хишиг-Өндөр	988	981					330	330	658	651
Хутаг-Өндөр	1 513	1 504					628	623	885	881



СУУЦНЫ ТӨРЛӨӨР

Нийт өрхийн 54.5 хувь нь гэрт, 40.1 хувь нь сууцны тусдаа байшинд, 2.7 хувь нь орон сууцанд, 0.2 хувь нь тохилог сууцанд, 1.6 хувь нь нийтийн байранд, 0.9 орон сууцны бус сууцанд тус тус амьдарч байна.

Хүснэгт 7. Өрхийн тоо сууцны төрлөөр, сумаар

Сум	Үүнээс					
	Гэр	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	Бусад сууц
	тоо					
Нийт	10 413	513	31	7 658	301	172
Баян-Агт	790	-	1	175	1	8
Баяннуур	428	2	-	89	2	2
Бугат	559	6	-	181	3	2
Булган	752	451	18	2,559	44	29
Бүрэгхангай	711	6	2	164	8	-
Гурван булаг	834	6	1	104	5	1
Дашинчилэн	742	2	-	179	-	2
Могод	650	2	-	188	-	5
Орхон	905	8	1	248	13	-
Рашаант	791	4	-	165	29	7
Сайхан	870	4	1	224	3	5
Сэлэнгэ	416	1	-	653	7	21
Тэшиг	68	-	1	925	3	10
Хангал	621	10	5	663	154	55
Хишиг-өндөр	615	6	-	353	1	3
Хутаг-Өндөр	661	5	1	788	28	22



СУУЦНЫ ЭЗЭМШЛЭЭР

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ?, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх вэ? зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгөх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Манай аймгийн хэмжээнд нийт өрхийн 0.2 хувь өөрийн гэсэн сууцгүй байна. Нийт өрхийн 0.9 хувь нь бусдын сууцанд түрээстэй амьдардаг бол 3.9 хувь нь бусдын сууцанд түрээсийн төлбөр төлөлгүй амьдарч байна.

Хүснэгт 8. Өрхийн тоо, сууц эзэмшлийн хэлбэрээр, сумдаар

Байршил	Үүнээс			
	Бусад	Өөрийн	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй
	тоо			
Нийт	38	18 126	184	739
Баян-Агт	1	947	3	24
Баяннуур	-	499	2	21
Бугат	2	726	4	19
Булган	7	3 646	49	151
Бүрэгхангай	-	858	4	29
Гурван булаг	-	940	3	8
Дашинчилэн	-	893	3	29
Могод	6	802	5	32
Орхон	2	1 091	20	62
Рашаант	4	945	13	34
Сайхан	1	1 076	6	24
Сэлэнгэ	7	1 025	9	57
Тэшиг	-	916	21	70
Хангал	5	1 411	29	63
Хишиг-Өндөр	1	928	3	46
Хутаг-Өндөр	2	1 423	10	70



ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Булган аймгийн дэд бүтцийн хөгжил бусад аймагтай харьцуулбал харьцангуй сайн ба технологийн дэвшлийн дагуу цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг айл өрхүүд өргөн хэрэглэх болсон.

Нийт өрхийн 51.0 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсвэрт, 39.9 хувь нь сэргээгдэх эрчим хүчинд холбогдож, цахилгааны эх үүсвэргүй айл өрх 312 буюу 1.6 хувь байна.

Сэргээгдэх эрчим хүч ашигладаг айл өрх нь сумдын малчид, тариаланчид бөгөөд нийт өрхийн 8.4 хувийг дизель станц болон бага оворын цахилгаан үүсгүүр сумын хөдөөгийн айл өрхүүд эзэлж байна.

Хүснэгт 9. Цахилгааны эх үүсвэр, сумдаар

Байршил	Үүнээс				
	Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оворын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
	тоо				
Нийт	9 748	103	7 627	1 502	312
Баян-Агт	216	1	627	100	26
Баяннуур	246	-	231	68	2
Бугат	249	1	306	214	8
Булган	3 676	15	161	14	32
Бүрэгхангай	376	-	418	157	9
Гурван булаг	185	51	702	32	7
Дашинчилэн	345	-	481	71	24
Могод	183	-	592	51	17
Орхон	285	1	772	38	69
Рашаант	445	1	455	85	6
Сайхан	244	-	602	255	24
Сэлэнгэ	724	1	215	123	26
Тэшиг	418	5	515	57	21
Хангал	994	22	399	104	9
Хишиг-өндөр	417	3	483	60	23
Хутаг-Өндөр	745	2	668	73	9



УНДНЫ УСАН ХАНГАМЖ

Аймгийн хэмжээнд нийт өрхийн 18.5 мянга буюу 97.2 хувийг зөөврийн усан хангамжтай өрх, 209 буюу 1.1 хувийг төвлөрсөн халуун хүйтэн устай өрх, 485 буюу 2.5 хувийг төвлөрсөн хүйтэн усан хангамжтай өрх эзэлж байна.

Хүснэгт 10. Усан хангамж, сумдаар

Байршил	Үүнээс				
	Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	Бие даасан систем - халуун, хүйтэн устай	Зөөврийн	Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай	Бие даасан систем - хүйтэн устай
	Тоо				
Нийт	209	15	18 556	485	28
Баян-Агт	-	1	968	1	-
Баяннуур	3	-	542	2	-
Бугат	7	-	771	-	-
Булган	127	8	3 340	415	9
Бүрэгхангай	6	-	946	8	-
Гурван булаг	6	1	969	1	-
Дашинчилэн	1	-	920	-	-
Могод	1	-	840	2	-
Орхон	11	-	1 154	-	-
Рашаант	5	-	987	-	-
Сайхан	6	1	1 115	2	1
Сэлэнгэ	3	-	1 081	3	2
Тэшиг	2	-	1 010	3	1
Хангал	22	2	1 449	46	9
Хишиг-өндөр	4	1	978	2	1
Хутаг-Өндөр	5	1	1 486	-	5



ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР

Нийт өрхийн 96.3 хувь нь ердийн галлагаагаар, 3.8 хувь нь төлөвлөрсөн систем, 0.6 хувь нь нам даралтаар, 0.16 хувь нь цахилгаан халаагуураар халаалтаа шийдсэн байна.

Хүснэгт 11. Халаалтын эх үүсвэр, сумдаар

Байршил	Үүнээс				
	Газрын гүний дулаан	Төвлөрсөн систем	Нам даралтын зуух	Цахилгаан халаагуур	Ердийн галлагаа
	тоо				
Нийт	2	739	134	30	18 388
Баян-Агт	-	1	4	1	964
Баяннуур	-	5	19	-	523
Бугат	-	13	2	1	762
Булган	1	565	41	13	3 279
Бүрэгхангай	-	22	3	-	935
Гурван булаг	-	8	6	-	963
Дашинчилэн	1	3	10	1	906
Могод	-	2	4	-	837
Орхон	-	20	1	-	1 144
Рашаант	-	9	1	3	979
Сайхан	-	17	4	2	1 102
Сэлэнгэ	-	11	1	-	1 077
Тэшиг	-	7	3	5	1 001
Хангал сум	-	43	19	2	1 464
Хишиг-Өндөр	-	5	10	1	970
Хутаг-Өндөр	-	8	6	1	1 482



БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ

Булган амьгийн нийт өрхийн 3.3 хувь нь төвлөрсөн системээр, 0.3 хувь нь бие даасан системээр, 49.3 хувь нь цооногт 47.1 хувь нь бохир усаа задгай асгадаг байна.

Хүснэгт 12. Бохир ус зайлуулалт, сумдаар

Байршил	Үүнээс			
	Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
	тоо			
Нийт	631	61	9 408	9 193
Баян-Агт	1		231	738
Баяннуур	4	5	248	290
Бугат	7		276	495
Булган	510	18	2 962	409
Бүрэгхангай	9	2	355	594
Гурван булаг	5	10	183	779
Дашинчилэн	1	3	239	678
Могод	3		119	721
Орхон	10	3	311	841
Рашаант	6	1	482	503
Сайхан	5	2	644	474
Сэлэнгэ	4	1	872	212
Тэшиг	1	4	568	443
Хангал	52	6	722	748
Хишиг-Өндөр	7	4	463	512
Хутаг-Өндөр	6	2	733	756

Булган аймгийн нийт өрхийн 47.1 хувь нь бохир усаа задгай асгаж байгаа нь орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байгааг анхаарч, цаашид гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай. Бохир ус зайлуулах тогтсон газар байхгүй байх нь хөрсний бохирдол, хүн амд халдварт өвчин тархах магадлалыг нэмэгдүүлж байна.



ХАТУУ ХОГ ЗАЙЛУУЛАЛТ

Байшинд амьдардаг өрхийн 22.5 хувь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь ихээхэн дэвшил гарсан байна. Нийт өрхийн 38.3 хувь нь зөвшөөрөгсөн цэгт, 38.8 хувь нь тогтсон цэг байхгүй газарт хатуу хог хаягдлыг ил зайдгайгаар хаяж байна.

Хүснэгт 13. Хатуу хог зайлуулалт

Байршил	Үүнээс				
	Шатаадаг	Булдаг	Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Тогтсон цэг байхгүй
	тоо				
Нийт	169	81	4 298	7 324	7 421
Баян-Агт	11	5	183	131	640
Баяннуур	19	5	25	254	244
Бугат	1	-	16	532	229
Булган	10	1	3 269	406	213
Бүрэгхангай	8	10	27	407	508
Гурван булаг	2	4	92	224	652
Дашинчилэн	20	16	285	139	461
Могод	19	1	3	222	598
Орхон	12	5	13	378	757
Рашаант	3	1	113	448	427
Сайхан	15	4	9	651	446
Сэлэнгэ	11	2	47	935	94
Тэшиг	13	15	8	482	498
Хангал	13	8	168	547	792
Хишиг-Өндөр	5	2	26	571	382
Хутаг-Өндөр	7	2	11	997	480

Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот суурин газруудад хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө.




СУРАЛЦАХ НӨХЦӨЛ

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуулийн 455 бүлэгт 11.4 мянган хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагын 135 бүлэгт 3.8 мянган хүүхэд хамрагдаж, эдгээрт ЕБС-ийн 671, СӨБ-ийн 255 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна.

Хүснэгт 14. Боловсролын салбарын зарим үзүүлэлт, *аймгаар*

Үзүүлэлт	2020-2021	2021-2022	2022-2023
	тоо		
Ерөнхий боловсролын сургуулийн тоо	22	22	22
Бүлгийн тоо	445	455	455
Үндсэн багшийн тоо	641	639	671
1-р ангид элсэгчид	1270	1129	1117
10-р ангид элсэгчид	543	582	716
Нийт суралцагчдын тоо	11124	11282	11401
Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо	1820	1626	1781
СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдийн тоо	4134	2804	3880
Бүлгийн тоо	150	139	135
МСҮТ-ийн тоо	1	1	1
Суралцагчид	403	340	478
ХААМСҮТ-ийн тоо	1	1	1
Суралцагчид	156	176	151

Зураг 5. Суралцагсадын тоо, бүлгээр





ЭРҮҮЛ АМЬДРАХ НӨХЦӨЛ

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 73 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас Нэгдсэн эмнэлэг 1, сум, тосгоны Эрүүл мэндийн төв 16, өрхийн эрүүл мэндийн төв 2, хувийн ортой , үүдэн 2, шүдний 4 эмнэлэг ажиллаж

байна.

Хүснэгт 15. Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2020	2021	2022
	тоо		
Нийт үзлэг	195 618	206 722	204 974
Ор хоног	74 762	122 610	80 900
Урьдчилан сэргийлэх үзлэг	53 407	81 881	48 600
Эмчлүүлсэн хүний тоо	10 901	15 433	11 136
Их эмчийн тоо	147	124	114
Бага эмчийн тоо	75	58	63
Эм зүйчдийн тоо	25	29	32
Түргэн тусламжийн дуудлага	13 802	12 424	13 781
үүнээс: алсын дуудлага	787	1 344	1 445
Осол гэмтлийн дуудлага	379	294	345
Нийт нас баралт	291	337	338
Эндсэн эхийн тоо	0	0	0
Үр хөндүүлсэн эхчүүдийн тоо	68	96	50
Амаржсан эх	760	836	677
үүнээс: амьд төрсөн хүүхэд	760	842	679
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	11	12	10
1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхэд	1	0	5

Эрүүл мэндийн байгууллагууд 204.9 мянган хүнд үзлэг хийснээс 23.7 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оноос нийт үзлэг 0.8 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 15.9 хувиар буурсан байна. Аймгийн 10000 хүнд 18.5 их эмч, нэг их эмчид 541.4 хүн ногдож байна.

Жилийн дүнгээр нэг иргэн дунджаар 3.3 удаа эмнэлэгт үзүүлсэн бөгөөд нэг хэвтэн эмчлүүлэгч дунджаар 7.3 хоног эмчлүүлсэн байна.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 онд нийт 467 хэрэгт 344 хүн холбогдон шалгагдаж хэргийн илрүүлэлт 55.3 хувьтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүртгэгдсэн хэрэг 20.4 хувиар, холбогдогч 24.4 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 0.7 хувиар өссөн байна.


Нийт бүртгэгдсэн хэргийн 79 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг, 22.2 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 23.1 хувь нь хүнд хэрэг байгаа ба өмнөх оноос согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 14 хувиар буурч, хүнд гэмт хэрэг 42.1 хувиар, хэрэг бүртгэлтийн хэрэг 61.1 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл: Нийт хэргийн 3.1 хувийг Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 17.3 хувийг хулгайн хэрэг, 22.7 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 6.2 хувийг Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 45.1 хувийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 9.2 хувийг Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 6.2 хувийг Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1705.2 сая төгрөгийн хохирол учирч, 24 хүн нас барж, 119 хүн хүнд ба хөнгөнөөр гэмтжээ. Нийт хохирлын 53 хувийг нь нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт холбогдсон 250 хүний 41.2 хувь нь эрхэлсэн ажилгүй, 36.8 хувь нь согтуугаар, 6.8 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 8 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож зөрчил гаргасан 551 жолоочийн эрхийг хасч торгуулийн арга хэмжээ авсан. Өмнөх оноос согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон зөрчлийн тоо 20.8 хувиар өссөн байна.

Зураг 6. Бүртгэгдсэн гэмт хэрэг



Хүснэгт 16. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн өнгөөр

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он
	Тоо		
Бүртгэгдсэн гэмт хэрэг	345	388	467
Илрүүлээгүй хэрэг	120	104	170
Илрүүлэлтийн хувь	52.2	54.6	55.3
Хэргийн өнгөөр:			
Хүнийг алах	5	11	6
Хүчиндэх	15	14	18
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	100	107	127
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	28	24	24
Хулгайлах	54	49	86
иргэдийн өмчийн хулгай	47	44	81
Малын хулгай	52	40	46
Дээрэмдэх	1	0	1
Залилах, хөрөнгө завших	6	30	61
Авилгын эсрэг	0	1	3
Бусад	41	68	14
Согтуугаар үйлдсэн хэрэг	93	121	104
Хүнд гэмт хэрэг	75	76	108
Хэрэг бүртгэлийн хэрэг /эзэнгүй хэрэг/	251	229	369
Гэмт хэрэгийн улмаас:			
Нас барсан	16	29	24
Гэмтсэн	122	131	119
Учирсан хохирол, сая.төг	1603.7	1197.8	1705.2
иргэдэд учирсан хохирол	948.1	1197.8	1323.5
нөхөн төлүүлсэн	892.0	826.5	839.2
Гэмт хэрэг үйлдэгсэд:	260	344	250
18 хүртлэх насны хүүхэд	15	26	25
Эрхэлсэн тодорхой ажилгүй	98	132	134
Согтуугаар	93	76	108
Гэмт хэрэг бүлэглэн үйлдэгч	35	83	33
Эрүүлжүүлэгдсэн хүн	828	787	501
Захиргааны шийтгэлээр баривчлагдсан	399	396	433
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон эрхээ хасуулсан	409	604	659

САНАЛ, ДҮГНЭЛТ

Манай аймгийн нийт өрхийн 54.5 хувь нь гэрт, 40.1 хувь нь сууцны тусдаа байшинд, 2.7 хувь нь орон сууцанд, 0.2 хувь нь тохилог сууцанд, 1.6 хувь нь нийтийн байранд, 0.9 орон сууцны бус сууцанд тус тус амьдарч байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2015 оноос орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдсэн хэдий ч нийт айл өрхийн дийлэнх буюу 60.5 хувь нь гэр хороололд оршин сууж байна.

Энэ тоо 2000 онд 45.6 хувь, 2010 онд 58.0 хувь, 2022 онд 60.5 байгаа нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд орлогын түвшнээсээ шалтгаалан орон сууц худалдан авах боломжгүйгээс гэр хороололд суурьшиж энэ тоо жилээс жилд тэлж буйг харуулж байна. Үүнтэй уялдан агаарын бохирдол хэмээх хар сөрөг зүйлийг үүсгэгч нэг үзүүлэлт нь гэр хорооллын айл өрхийн хэрэглээнэс гарч буй утаа юм. Үүнийг багасгах дараах саналыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

1. Томоохон шинэ орон сууцны хотхоныг барьж, ашиглалтанд оруулах.
2. Барилын материалын үйлдвэрлэл, ажиллах хүчний чадавхийг дээшлүүлэх. Ингэсгээр орон сууцны өртөг буурч, дундаас доош орлоготой өрхийн орон сууц худалдан авах боломж нэмэгдэнэ.
3. Банк, санхүүгийн байгууллагын хувьд дундаж орлогтой өрхийн орон сууц худалдан авах боломжийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл барьцааны хэмжээг багасгах.
4. Бага орлоготой өрхүүдийг хямд үнэтэй нийтийн байраар хангах боломжийг бүрдүүлэх.

Булган аймгийн нийт өрхийн 0.2 хувь нь өөрийн эзэмшлийн сууцгүй, 1.6 хувь нь цахилгаангүй байгаа нь таагүй үзүүлэлт юм.

2022 онд аймгийн өрхийн дийлэнх хувь буюу 96.3 хувь нь ердийн галлагаатай байна. Байшинд амьдардаг өрхийн 22.5 хувь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь ихээхэн дэвшил гарсан байна. Нийт өрхийн 38.3 хувь нь зөвшөөрөгдсөн цэгт, 38.8 хувь нь тогтсон цэг байхгүй газарт хатуу хог хаягдлыг ил зайдгайгаар хаяж байна.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл хүн амыг цахилгаанаар хангаж, төвлөрсөн болон төвлөрсөн бус байдлаар эрчим хүчний эх үүсвэрийг шийдэх, хүн амыг орон сууцжуулах бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлсэн арга хэмжээ бодитой үр дүнд хүрсэн нь орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс харагдаж байна. Түүнчлэн сууцны халаалт, дулаан, ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийн хувьд улам бүр сайжруулах үүднээс арга хэмжээ авах хэрэгтэй байна.



Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ?



www.1212.mn

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

bulgan.nso.mn

Хэлтсийн вэб сайт



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл
авах 1212.mn аппликейшн



/StatisticBulgan



1900-1212

70342766

1 минут=200 төгрөг